



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар №148

Тендер шалгаруулалтын дугаар: ДААТҮТӨХК/20260403656
Төсөвт өртөг: 9,500,000 төгрөг

2026.06.10

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Төмөртолгойн уурхайн палеонтологийн судалгааны ажил	шир	1.0	Ажил гүйцэтгэгч нь археологи, угсаатан зүй, палеонтологийн эрдэм шинжилгээний хайгуулын тухай эрх зүйн баримт бичигт заасны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас олгогдсон тусгай зөвшөөрөлтэй байна.

ТӨМӨРТОЛГОЙН УУРХАЙН ПАЛЕОНТОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Зориулалт:

- ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын Соёлын өвийн судалгаа хийх журмыг үндэслэн судалгааны ажил явуулах ба судалгааны ажлыг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.

2. Тавигдах шаардлага:

- ✓ Ажил гүйцэтгэгч нь археологи, угсаатан зүй, палеонтологийн эрдэм шинжилгээний хайгуулын тухай эрх зүйн бичиг баримт бичигт заасны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас олгогдсон тусгай зөвшөөрөлтэй байна.
- ✓ Эрдэмтэн, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан нь тухайн чиглэлээр ажилласан ажлын дадлага туршлагатай байна.

3. Хийгдэх ажлын мэдээлэл:

Талбайн нэр:	Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Төмөртолгойн ил уурхай
Судалгааны ажлын зорилго:	✓ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу лицензийн талбайн хэмжээнд хайгуул судалгааны ажил явуулж геологи хайгуулын үр дүнгийн нөөцийн тодотгол тайланд ажлын тайланд үр дүнг тусгаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн баталгаажуулахад палеонтологийн судалгааны тайланг хавсаргах зорилготой.
Судалгааны үр дүнд хийгдэх ажлууд:	✓ Судалгааны ажлыг Монгол Улсын нутагт археологи, угсаатан зүйн хайгуул судалгааг хийх журмын дагуу салбарын шинжлэх ухааны үндэстэй арга зүйгээр гүйцэтгэнэ. ✓ "Дарханы Төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн журам, заавартай танилцаж, ажиллах нэвтрэх зөвшөөрөл авах, гүйцэтгэгч тал өдөр тутмын зааварчилгааг тогтмол хангаж ажиллах
Ажиллах нөхцөл, голлох эрдэс:	✓ Уул техникийн нөхцөл дөрөвдөгчийн хурдас тархсан, шар шаварлаг, уулархаг, хадархаг. Голлох эрдэс магнетит (Fe ₃ O ₄), Уурхайн лицензийн талбайд судалгааны ажил явуулна.

<p>Судалгааны арга:</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Монгол Улсын “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн /шинэчилсэн найруулга 2023 он/ 5-р бүлгийн 27-р зүйлийн 8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна” ✓ 27.10-т “Урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно” хэмээн тус тус заасны дагуу хийж гүйцэтгэх ✓ 29.1-т заасан “Соёлын өвийн судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлангийн нэ хувийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх” ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/141 тоот тушаалын гуравдугаар хавсралт Соёлын өвийн судалгаа хийх журмыг үндэслэн судалгааны ажил явуулна.
<p>Тавигдах шаардлага, тусгай нөхцөл:</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Ажил гүйцэтгэгч нь археологи, угсаатан зүй, палеонтологийн эрдэм шинжилгээний хайгуулын тухай эрх зүйн бичиг баримт бичигт заасны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас олгогдсон зөвшөөрөлтэй байна. ✓ Мэргэжлийн эрдэмтэн, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан зэрэг боловсон хүчнээр хангагдсан байна. ✓ Судалгааны ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжүүдийг Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.
<p>Мөрдөх хууль тогтоомж, стандарт, журам, эрх зүйн баримт бичгүүд:</p>	<ul style="list-style-type: none"> ✓ “Монгол Улсын Үндсэн хууль” ✓ “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” ✓ Боловсрол шинжлэх ухааны сайдын 2015 оны 01 сарын 24-ний өдрийн А/141 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Соёлын өвийн судалгаа хийх журам” ✓ Уул уурхайн сайдын 2015 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Ангилал, заавар батлах тухай” ✓ Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж, ашигт малтмалын эрэл хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, төмрийн хайгуулд хэрэглэгддэг орчин үеийн аргачилсан зөвлөмж, бусад холбогдох журам, норм, стандартууд
<p>Судалгааны үр дүнг тайлагнах, тайлан хүлээлгэж өгөх:</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Судалгааны ажлын тайланг мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулан Захиалагч талд хүлээлгэж өгөх ба тайланг Монгол хэл дээр бичиж 2% үйлдэж, цаасан болон цахим (DOCX) хэлбэрээр хүлээлгэж өгөх ✓ Тайлангийн бичвэр мэдээлэл нь Монгол хэлний найруулга зүйд нийцсэн, алдаагүй бичигдсэн байх ✓ Судалгааны ажлын явц, үр дүнг бүрэн илэрхийлсэн бичвэр, гар зураг, гэрэл зурагтай, судалгааны үр дүнгийн талаарх шинжлэх ухааны урьдчилсан дүгнэлттэй байх ✓ Судалгааны тайланг боловсруулсан эрдэмтэн, судлаачид, эрдэм шинжилгээний ажилтнуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх ✓ Дээрх мэдээллийг судалгааны тайланд тусгасан байна.

4. Нэмэлт мэдээлэл:

	<ul style="list-style-type: none"> ✓ Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших Төмөртолгойн уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд хийгдэнэ. ✓ Судалгааны ажилтай холбоотой зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.
--	---

5. Ажлын төлөвлөгөө:

<p>Ажил гүйцэтгэх хугацаа:</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Үр дүнгийн тайланг баталгаажуулан “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-ийн УУГҮХ, ГА-д хүлээлгэж өгнө. ✓ Захиалагч болон ажил гүйцэтгэгч талууд гэрээнд гарын үсэг зурснаас эхлэн ажлыг эхлүүлж үр дүнгийн тайланг боловсруулж зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулснаар дуусгавар болно. ✓ Гэрээт ажлыг 14 хоногийн хугацаанд багтаан гүйцэтгэх ба дээж шинжлүүлж эхлэх өдрийг Захиалагч талтай зөвшилцөж шийдвэрлэнэ.
---------------------------------------	---

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг бараа нийлүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, ажил гүйцэтгэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт
- Ажлын даалгавар, танилцуулга, бусад нотлох баримт
- Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл, утасны дугаар

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

**Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах хаяг:**

Худалдан авалтын хэлтэс

/procurement@dmp.mn/

Утас: 7509-0044